

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Улаанбаатар түншлэл төв” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/040/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал Утас: 70007734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn</p> <p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: С.Гантөгс Утас: 315093 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Цолмон Утас: 325093 Цахим хаяг: tsolmonba@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Соёлын төв өргөө Г корпус, 5 давхар,
А.Амарын гудамж, 8 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: (976) 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
Цахим шуудан: Ub@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.13 № 311
танай _____ -ны № _____ -т

УЛААНБААТАР ТҮНШЛЭЛ ТӨВ
ХХК-ИЙН ЗАХИРАЛ З.БАТЫРБЕК
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Улаанбаатар түншлэл төв" ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Улаанбаатар түншлэл төв ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Улаанбаатар түншлэл төв ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 144.2 сая төгрөгийн залруулаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх", "үнэн зөв байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Улаанбаатар түншлэл төв ХХК-ийн дүрмийн сангийн хөрөнгөд зориулж 2,746.0 сая төгрөгөөр баталж, санхүүжүүлсэн байна. Тайлант онд 72.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 247.5 сая төгрөгийн зардал гарган, 175.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

C:\Users\varengua_j\Desktop\Баяр эрээр 2026\2026\word\ywsan_bichig\Dugnet_2026.docx

1426051992

Аудитын гол асуудал

Улаанбаатар түншлэл төв ХХК нь Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 25/24 дүгээр тогтоолоор байгуулагдсан байна.

Бусад асуудал

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тайлант онд 28 зорилтын хүрээнд 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 95.4 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан***/төгрөгөөр/*

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
2001.01.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	0	645,427,265.35
2001.01.02	Дансны авлага	0	17,298,875.98
2001.02.11	БИЕТ БУС ХӨРӨНГӨ	0	1,797,079,551.28
2001.01.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	0	2,459,805,692.61
2001.02.01	Тоног төхөөрөмж	0	242,000,596.43
2001.02.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	0	242,000,596.43
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	0	2,701,806,289.04
2.1.1.1	Дансны өглөг	0	128,863,464.84
2.1.1.3	Татварын өр	0	2,118,921.99
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	0	130,982,386.83
2.2	Өр төлбөрийн нийт дүн	0	130,982,386.83
2.3	Эздийн өмч	0	2,746,078,700.00
2002.03.01	Өмч: - төрийн	0	2,746,078,700.00
2002.03.09	Хуримтлагдсан ашиг	0	-175,254,797.79
2002.03.11	Эздийн өмчийн дүн	0	2,570,823,902.21
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	0	2,701,806,289.04

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан*/төгрөгөөр/*

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (Цэвэр)	0	32,995,000.00
3	Нийт ашиг (алдагдал)	0	32,995,000.00
5	Хүүний орлого	0	10,596,869.51
8	Бусад орлого	0	27,638,896.45
10	Ерөнхий ба удирдлагын зардал	0	246,485,563.79
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	0	-175,254,797.83
20	Татварын дараах ашиг (алдагдал)	0	-175,254,797.83
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	-175,254,797.83
28	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0	-175,254,797.83

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Мөнгөн орлогын дүн (+)	0	49,499,164.60
##	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	0	32,785,000.00
##	ҮҮА-ны бусад мөнгөн орлого	0	16,714,164.60
1	Мөнгөн зарлагын дүн (-)	0	1,967,239,958.76
##	Ажиллагчдад төлсөн	0	541,963,038.10
##	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	0	173,806,893.47
##	Бараа материал худалдан авахад төлсөн	0	19,416,985.40
##	Ашиглалтын зардалд төлсөн	0	406,781,997.60
##	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	0	341,840.00
##	Татварын байгууллагад төлсөн	0	62,481,125.26
##	ҮҮА-ны бусад мөнгөн зарлага	0	762,448,078.93
1	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0	-1,917,740,794.16
2	Мөнгөн орлогын дүн (+)	0	10,596,869.51
##	Хүлээн авсан хүүний орлого	0	10,596,869.51
2	Мөнгөн зарлагын дүн (-)	0	193,207,510.00
##	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0	168,947,530.00
##	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0	24,259,980.00
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0	-182,610,640.49
3	Мөнгөн орлогын дүн (+)	0	2,746,078,700.00
##	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0	2,746,078,700.00
3	Мөнгөн зарлагын дүн (-)	0	300,000.00
##	СҮА-ны бусад мөнгөн зарлага	0	300,000.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0	2,745,778,700.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	0	645,427,265.35
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	645,427,265.35

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	0	0	0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0	0	0
3	Залруулсан үлдэгдэл	0	0	0
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	0	0
5	Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0
6	Өмчид гаргасан өөрчлөлт	0	0	0
7	Зарласан ногдол ашиг	0	0	0
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0	0	0
9	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	0	0	0
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0	0	0
11	Залруулсан үлдэгдэл	0	0	0
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	-175,254,797.79	-175,254,797.79
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0
14	Өмчид гарсан өөрчлөлт	2,746,078,700.00	0	2,746,078,700.00
15	Зарласан ногдол ашиг	0	0	0
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0	0	0
17	2025 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	2,746,078,700.00	-175,254,797.79	2,570,823,902.21

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Борлуулалтын орлого	0.00	60,633,896.45	-60,633,896.45	-
Бусад орлого	-	32,995,000.00	(32,995,000.00)	-
Үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгө	-	27,638,896.45	(27,638,896.45)	-
Борлуулалтын өртөг	-	-	-	-
Бусад зардал	-	-	-	-
Нийт ашиг	-	60,633,896.45	(60,633,896.45)	-
Үйл ажиллагааны зардал	305,000,000.00	246,485,563.75	58,514,436.25	-
Томилолтын зардал	150,000,000.00	90,482,812.80	59,517,187.20	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	150,000,000.00	150,000,000.00	-	-
Тендер бичиг баримтын зардал	5,000,000.00	4,943,064.00	56,936.00	-
Үйл ажиллагааны ашиг	(305,000,000.00)	(185,851,667.30)	(119,148,332.70)	-
Санхүүгийн ашиг	10,596,869.51	10,596,869.51		-
Хүүгийн орлого	11,656,556.46	11,656,556.46		-
ОАТ зардал	1,059,686.95	1,059,686.95		-
Татварын өмнөх ашиг	(294,403,130.49)	(175,254,797.79)	(119,148,332.70)	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 144,244.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөв.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

ДӨРӨВ.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг орхигдуулсан		Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд авлагыг данс бүртгэлд тусгаагүй байна	1	17,288.9	1	17,288.90	1	17,288.9
Дүн	1	17,288.90	1	17,288.90	1	17,288.9

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчил

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:					
			Акт	Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо		Тоо	Дүн	Тоо	Дүн
Албан томилолтоор ажилласан 46,889.1 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна	1	46,889.1					1	46,889.1
Тайлант онд нээлттэй тендер зарлаагүй 97,355.0 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна	1	97,355.0		-	-		1	97,355.0
Дүн	2	144,244.1		-	-		1	144,244.1

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:					
			Акт	Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт								
Өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдэд сар бүр 21,266.1 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.	1	21,266.1		-	1	21,266.1		
Тайлант онд зах зээлийн үнээс өндөр үнээр 16,308.8 мянган төгрөгийн смарт цоож хийлгүүлсэн байна	1	16,308.8		-	-	-	1	16,308.8
Дүн	2	37,574.9		-	1	21,266.1	-	1-16,308.8



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 583/А06.10461

Улаанбаатар хот

НТАГ-2026/040/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улаанбаатар түншлэл төв ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдэд ажлын гүйцэтгэлийг үл харгалзан сар бүр буюу нийт 21,266,100.00 (хорин нэгэн сая хоёр зуун жаран зургаан мянга нэг зуу)-н төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйл 10.2-д "Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно", 15 дугаар зүйл 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдэд сар бүр урамшуулал олгосон зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт^[1] ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улаанбаатар түншлэл төв ХХК-ийн захирал З.Батырбек, нягтлан бодогч Ц.Лхагвасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
С.ГАНТӨГС
Б.ЦОЛМОН

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426391106

